



Оног тутмын хэвлэл
№ 09 дүгээр сарын 26
№36 /705/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
асгийн газрын
тогтоол

433

**Хөдөө аж ахуйн гаралтай
бараа, түүхий эдийн бирж
байгуулах бэлтгэл хангах
зарим арга хэмжээний
тухай**

Монгол Улсын
асгийн газрын
тогтоол

436

Журам батлах тухай



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

354.	Түүх, соёлын дурсгалд хамааруулах тухай	Дугаар 234	1433
355.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай	Дугаар 235	1434
356.	Журам батлах тухай	Дугаар 236	1436

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 234

Улаанбаатар
хот

Түүх, соёлын дурсгалд хамааруулах тухай

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.3, 21.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яамны Тэргүүн сайд асан, Монгол төрийн нэрт зүтгэлтэн Да лам Цэрэнчимэдийн дурсгалд зориулан Богд хааны зарлигаар 1914 онд бүтээсэн гэрэлт хөшөөг улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалд хамааруулсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 175 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт"-ын "18. Увс аймаг, Улсын хамгаалалтад байх түүх, соёлын дурсгал" гэсэн хэсэгт "6. Хяргас сумын нутаг, Цогтхайрхан уулын бэлд орших Да лам Цэрэнчимэдийн гэрэлт хөшөө" гэж нэмсүгэй.

3. Да лам Цэрэнчимэдийн гэрэлт хөшөөг мэргэжлийн байгууллагаар сэргээн засварлуулж бэхжүүлэх, хамгаалалтын хашааг барьж байгуулахад зориулан 25.0 (хорин таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.



4. Гэрэлт хөшөөний хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр, Увс аймгийн Засаг дарга Э.Цасчихэр нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

Ё.ОТГОНБАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 235

Улаанбаатар
хот

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай

"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг үндэслэн Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл хангах, сургалт зохион байгуулах, хууль сурталчлах чиг үүрэг бүхий нэгжийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын дэргэд байгуулж, орон тооны дээд хязгаарыг 7 байхаар тогтоосугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан нэгжийн 2011 оны үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцаас, 2012 оноос эхлэн холбогдох зардлыг төсөвт тусган санхүүжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

4. Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж байгуулах бэлтгэл ажилд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсүгэй.



5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн явц, дүнг улирал бүр Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2011 оны 235 дугаар
тогтоолын хавсралт

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН БИРЖ
БАЙГУУЛАХ БЭЛТГЭЛ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах яам, агентлаг
1.	Дараахь хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх: -Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай -Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2011 оны IV улирал	СЯ, ХХААХҮЯ, ХЗДХЯ, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)
2.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2011 оны III, IV улирал	ХХААХҮЯ
3.	Бололцоотой аймаг, сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбож, биржийн цахим арилжаа явуулах нөхцөлийг төв, орон нутагт бий болгох	2011-2012 он	МШХХТГ
4.	Биржийн программ хангамжийг шинээр боловсруулах, эсхүл гадаадын биржийн программ хангамжийг хэрэглэх ажлыг судлан шийдвэрлэх	2011-2012 он	ХХААХҮЯ, МШХХТГ
5.	Биржийн дүрэм, хяналт тавих журмын төслийг боловсруулж батлах	2012 оны II улирал	ХХААХҮЯ, СЗХ
6.	Биржийн арилжаанд оролцогчдын үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр дараахь баримт бичгийн төслийг боловсруулж батлах: -Арилжааны журам -Төлбөр, тооцооны журам -Барааг хадгалах, тээвэрлэх журам -Бараа, түүхий эдийг гаджуулах журам -Биржээр арилжих бараа, түүхий эдийн жагсаалт -Бусад	2011-2012 он	ХХААХҮЯ, СЯ, ЭТБХБЯ, СЗХ, МХЕГ, ГЕГ, СХЗГ, холбогдох мэргэжлийн холбоод



7.	Биржийн чиглэлээр гадаад, дотоодын их, дээд сургуульд суралцаж төгссөн болон суралцаж байгаа монгол иргэдийн судалгааг гаргаж, бирж байгуулахад шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах	2011-2012 он	ГХЯ, БСШУЯ, ХХААХҮЯ
8.	Биржийн удирдлагын баг, зарим мэргэжлийн хүнийг гадаадад сургах, гадаадын адил төстэй биржид дадлага хийлгэх	2011-2012 он	ХХААХҮЯ, ГХЯ, БСШУЯ, СЗХ, Хувийн хэвшил
9.	"Биржийн менежмент, худалдаа" хичээлийн хөтөлбөр боловсруулж, холбогдох их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгах	2011 оны 9 дүгээр сарын 1-нээс	БСШУЯ, ХХААХҮЯ, СЗХ
10.	Биржийн арилжаанд оролцогч (брокер, хоршоо)-дыг сургах сургагч багш нарыг бэлтгэх, биржийн хяналт, зохицуулалт хариуцсан ажилтнуудыг сургаж бэлтгэх	2011-2012 он	ХХААХҮЯ, СЗХ
11.	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг сургах сургагч малчин-багш бэлтгэх	2011-2012 он	ХХААХҮЯ, МШХХТГ, мэргэжлийн холбоод
12.	Бараа, түүхий эдийн болон агуулах, тээврийн стандартыг хянаж шаардлагатай бол зарим стандартыг шинэчлэх, олон улсын стандартыг нутагшуулах	2011 оны III, IV улирал	СХЗГ, ХХААХҮЯ, МХЕГ
13.	Бараа, түүхий эдийг хүлээн авч анхан шатны тордолт хийх байр, талбай, хадгалах агуулах болон тээврийн хэрэгсэл, лабораторийн судалгаа гаргаж, тэдгээрийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж бэлэн байдлыг хангах	2011-2012 он	ХХААХҮЯ, ЭТБХБЯ, Авто тээврийн газар, СХЗГ, МХЕГ, аймаг, сумын Засаг дарга
14.	Биржийн арилжаанд оролцох биржийн арилжааны зуучлагч (брокер), хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн загвар хоршоог сумдад байгуулж чадавхижуулах, аагвар хоршооны туршлагыг улсын хэмжээнд дэлгэрүүлэн сурталчлах	2011-2012 он	ХХААХҮЯ, аймаг, сумын Засаг дарга
15.	Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс болон сумдын Засаг даргын Тамгын газрын мал эмнэлэг, үржлийн тасгийг бэхжүүлэх, тэдгээрт ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх	2011-2012 он	ХХААХҮЯ, МХЕГ, СХЗГ, аймаг, сумын Засаг дарга
16.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, биржийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах	2011-2012 он	МҮОНРТ, аймаг, сумын Засаг дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2011 оны 7 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн б.г.б, д.г.б-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хил, гаалийн хялбарчилсан шалгалт хийх, навигацын болон бусад үйлчилгээ үзүүлэх журам"-ыг 1 дүгээр, "Сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2004 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаар тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 133 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД**

Л.БОЛД

Засгийн газрын 2011 оны 236 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ХИЛ, ГААЛИЙН ХЯЛБАРЧИЛСАН ШАЛГАЛТ ХИЙХ, НАВИГАЦЫН БОЛОН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 6.1.6-д заасан хил, гаалийн хялбарчилсан шалгалт хийх, навигацын болон бусад үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Хил, гаалийн хялбарчилсан шалгалт

2.1. Бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд иргэний гадаад паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичгийг үндэс болгоно.

2.2. Цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага нь дор дурдсан мэдээллийг хил хамгаалах болон гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бие бүрэлдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхээр төлөвлөсөн хугацаанаас 14 хоногийн өмнө хүргүүлнэ:

2.2.1. бие бүрэлдэхүүний албан тушаал, нэрсийн жагсаалт;

2.2.2. зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийн жагсаалт, төрөл, тоо хэмжээ;

2.2.3. нэвтрэх хилийн болон гаалийн боомт, аяллын маршрут.



2.3. Хил хамгаалах болон гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэхүү журмын 2.2-т заасан мэдээллийн хүрээнд хилийн болон гаалийн хялбарчилсан шалгалт хийх байцаагчийг томилон бэлтгэлийг хангуулна.

2.4. Цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллагын хүсэлтээр хилийн болон гаалийн шалгалтыг холбогдох журмын дагуу, ажлын бус цагаар хяналтын бус талбайд хийж болно.

2.5. Хялбарчилсан шалгалтын үед хил, гаалиар нэвтрүүлэх бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийг бичиг баримттай тулган шалгаж, холбогдох баримт бичигт тэмдэглэл үйлдэнэ.

2.6. Зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийг улсын болон гаалийн хилээр нэвтрүүлэх үед өөрчлөлт орсон бол цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага мэдүүлгийг хил, гаалийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад нэн даруй гаргана.

Гурав. Навигацын үйлчилгээ

3.1. Бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийг тээвэрлэх агаарын хөлөг нь зохих журмын дагуу урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын агаарын орон зайд нислэг үйлдэнэ.

3.2. Энэхүү журамд заасан үүрэг гүйцэтгэх агаарын хөлгийн талаар эзэмшигч, эсхүл түрээслэгчээс урьдчилан ирүүлсэн мэдэгдлийн дагуу цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага дараахь үүргийг хүлээнэ:

3.2.1. агаарын хөлгийг хүлээн авах бэлтгэл ажлыг зохион байгуулах;

3.2.2. агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах;

3.2.3. агаарын хөлөг иргэний нисэхийн агаарын зам, нисэх буудлыг ашиглах шаардлагатай бол энэ тухай иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 30 хүртэл хоногийн өмнө мэдэгдэх, хойшлуулшгүй тохиолдол болон онцгой нөхцөл байдалд нислэгийн захиалгыг 5 хүртэл хоногийн өмнө өгсөн байх.

3.3. Нислэгийн захиалгыг Монгол Улсын аэронавигацийн мэдээллийн эмхтгэл (AIP)-д заасны дагуу үйлдэнэ.

3.4. Нисэх буудлын аюулгүй байдлыг хангах байгууллага нь



агаарын хөлгийн зогсоол дээрх аюулгүй байдлын харуул, хамгаалалтыг хариуцна.

3.5.Эзэмшигч, эсхүл түрээслэгчийн захиалгаар тухайн агаарын хөлөгт үйлчилгээ (шатахуунаар хангах, бусад үйлчилгээ) хийсэн тохиолдолд холбогдох зардлыг агаарын хөлгийг эзэмшигч, эсхүл түрээслэгч хариуцна.

3.6.Монгол Улсын цэргийн баг, цэргийн тусламжийн бараа тээвэрлэх зорилгоор нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн навигацын төлбөрийг Нэгдсэн Үндэстний Байгууллага, бүс нутгийн холбогдох байгууллага, бусад улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв. Бусад тээврийн хэрэгслийн үйлчилгээ

4.1.Цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага энхийг дэмжих ажиллагааны бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийг төмөр замын тээвэрээр хил нэвтрүүлэх, хөдөлгөөнд оролцуулах тохиолдолд энэ тухай захиалгыг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 30 хүртэл хоногийн өмнө, хойшлуулшгүй тохиолдол болон онцгой нөхцөл байдалд захиалгыг 5 хүртэл хоногийн өмнө өгсөн байна.

4.2.Захиалгад төмөр замын тээврийн хэрэгслийн харьяалал, төрөл, тоо, аяллын хугацаа, хүрэх, дамжин өнгөрөх өртөө, байрлах хугацаа, бие бүрэлдэхүүний тоо, зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийн жагсаалт, тоо хэмжээ, жинг заана.

4.3.Энхийг дэмжих ажиллагаа, сургалт, дадлагад оролцох бие бүрэлдэхүүн, зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, хангалтын эд зүйлсийн тээвэрлэлтийн аюулгүй байдлыг цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага, агаарын, төмөр замын болон авто тээврийн байгууллага цагдаагийн байгууллагатай хамтран хангана.

Засгийн газрын 2011 оны 236 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

СЭТГЭЛ ЗҮЙ, БИЕ БЯЛДРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ, СУВИЛАХ ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЖУРАМ

1. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 6.1.8-д зааснаар энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлыг энэхүү журмаар зохицуулна.



2. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 3.1.2-т заасан бие бүрэлдэхүүний (цаашид "цэргийн алба хаагч" гэх) сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах зардлыг Батлан хамгаалахын сайдын төсвийн багц дахь Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.

3. Цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага нь энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн албан хаагч бүрийг эрүүл мэндийн үзлэг оношилгоо, нөхөн сэргээх сувилалд хамруулах ажлыг зохион байгуулна.

4. Энхийг дэмжих ажиллагааны явцад цэргийн албан хаагчийн олсон өвчин эмгэг, гэмтлийг оношлох, эмчлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд цэргийн албан хаагчийн өөрөө төлбөл зохих эмнэлгийн ор хоног, оношилгооны зардлыг энэ журмын 2 дахь заалтад заасан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5. Цэргийн албан хаагчид өндөр өртөгтэй эмчилгээ шаардлагатай тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27.1.8-д заасны дагуу шийдвэрлэж, зардлын үлдэх хэсгийг энэ журмын 2 дахь заалтад заасан эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

6. Цэргийн албан хаагчийг сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээлт, сувиллын аль төрөлд хамруулах, түүний амрах хугацаа, сувилах үйлчилгээний хэмжээг цэргийн мэргэжлийн эмч нарын комисс тогтооно.

7. Сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх, сувилах хоногийн зардлын хэмжээг батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага улсын эмнэлэг, сувилал, амралтын газрын нөхөн сэргээх эмчилгээ, үйлчилгээний зардлын дунджаар тооцон жил бүр тогтооно.

8. Цэргийн албан хаагчийн сэтгэл зүй, бие бялдрыг нөхөн сэргээх зардлыг амралт, сувилал, эмнэлгийн байгууллагад шилжүүлнэ.

Ханг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци.


Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 0.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487